ОЛОН УЛСЫН МОНГОЛ СУДЛАЛЫН ХОЛБОО
МЕЖДУНАРОДНАЯ АССОЦИАЦИЯ МОНГОЛОВЕДЕНИЯ
INTERNATIONAL ASSOCIATION FOR MONGOL STUDIES

ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТНИЙ V ИХ ХУРАЛ
ПЯТЫЙ МЕЖДУНАРОДНЫЙ КОНГРЕСС МОНГОЛОВЕДОВ
FIFTH INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

2

Ерөнхий редактор: Ш. Бира

Улаанбаатар · 1992

Масару Камимото /Япон/

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДЭЭР ГАРАХ temγu-/ 赤古 / ГЭСЭН ХЭЛБЭРИЙН ТУХАЙ

Ерөнхийдөө Монголын Нууц Товчон дээр авиалбарын болон бүтээврийн зүйн талаар үзсэн ч маш сонирхолтой хэлбэрүүд нилээн гарна. Тэгээд би энэ өчүүхэн илтгэлээ үйл үг temγu- /赤古/ гэсэн хэлбэрийн тухай бодож үзье.

Монголын нууц товчоонд үйл үгийн үндэс temgü-./түүх гэсэн утгатай/ хоёр удаа тохиолдоно.

§26 亦那困 亦哇麦史渡 赤古勒都困 亦哇歡噶斡歡論
cino-yin idegsen-ni temgüldüjü ide'ed o'er-ün
哈兒赤答安 哈兒赤孩巴安 別兒帖兒額勒爽 帖剌桓 哈兒罷
qo'olai-da'an qarciqai-ba'an ber teji'eldün tere hon qarba.

Дамдинсүрэн гуай /1976/ үүнийг ингэж хөрвүүлж байна.
чоныи идсэн сэгийг түүж гэдсээн хооллож харцагаа тэжээсээр тэр он гарав.

Бас нэг жишээ дурдвал,

§74 鈔能沐闊遲 斡額迷 亦剌答 答禿困 斡里兒孩 抹亦勒孩,
Onan müren o'ede irada güiju oiirsun moilsun
赤古困 兀都兒 雪你 哈兒斡來 帖兒額罷
temgüju üdür soni qo'olai teji'eba.

Дамдинсүрэн гуай үүнийг бас ингэж хөрвүүлж байна.
Онон мөрнийг өгсөж уруудаж
Олирс /sic/ мойлыг түүж явж
Өчүүхэн хөвүүдээ хайрлан тэжээж . . .

Энэ хоёр жишээн дээрх temgu- нь хуучин бичгийн хэлний хэлбэр tegu-/ энд тэндээс цуглуулж хураан авах/-д таарна. Хэл бичгийн хэлбэр tegu- гэсэн үндсээр таамаглагдах дундад зууны монгол хэлний хэлбэр бол te'u- боловч энэ хэлбэр нь Монголын Нууц Товчоонд ерөөс үзэгдэхгүй байна.

Лундад зууны хэлний нэг аман аялгуу заасан "Мукаддимат ал -Адаб" гэсэн толь бичиг дээр нэг удаа temgübe "собирал" /цуглуулав, хурааб, түүв/ болох үйл үгийн хэлбэр гарна. Үүнээс үзэхэд баруун болон зүүн дундад зууны монгол хэлнүүдэд түгэж байсан гэж болно.

Тэгээд орчин цагийн монгол хэлнүүдэд ямар хэлбэр нь тохирох вэ гэвэл, халх -түү, цахар -tü-, бурят. түү-, халимаг tü-, ордос t'ü-, дагуур teü- гэх мэт.

Дээр дурдсан жишээнээс дагуур хэлэнд үндэс нь teu- болж түүнээс бусад хэлнүүдэд tu- болж байна. Дагуур хэлний хэлбэр нь tegu- гэсэн хэлбэрээс хөгжиж хувирсан юм гэж үзэж болно.

Гэхдээ хятад дахь монгор хэлэнд тунгу- "поднимать, подбирать" /өргөх, түүж авах, цуглуулж авах/, "собирать" /цуглуулах/ /Тодаева 1973, 367 тал/, tungu-"抹,拾" 土汉对照词汇 "t'unGu- "ramasser, recueillir", e.g., yäse t'unGu- "ramasser les os" (de Smedt, A. Mostaert 1933, p. 367) болж баоан хэлэнд tunga-"拾(保存)" – "собират" /цуглуулах/ болж байна. (гоо. Р. 1948)

Дээрх жишээнүүдээс монгор болон баоан хэлнүүд дахь тунгу- "цуглуулах" нь Нууц Товчоон дахь temgu-д тохирох нь тодорхой юм. Тус тунгу- гийн нэгдүгээр үеийн у бол ухран ижилших /ассимиляция регрессивная/-ээр э-гээс хувирсан авиалбар /и/ юм гэж үзэж болно биз дээ. Тийм байдлаас үзэхэд монгол өвөг хэлний хэлбэрээр temgu- г дахин бүтээх нь боломжтой бодогдоно.

Түүнчлэн манж хэлэнд нэг гаралтай гэж үзэлтэй үгний хэлбэр tungiye – "өргөх, түүж авах", туңгэ –"собирать" /Цинциус 1975-1977, 2-р боть, 215 тал/ болж шибэ хэлэнд /сибинский диалект/ tina- "өргөх, түүж авах" /锡伯语简志 p. 156/ tiuni – Atiyni-U to pick up" /Ямамото 1969, 70 тал/ гэсэн үгний үндэс үзэгдэнэ. Манж бичгийн хэлний тунгэ- болон шибэ хэлний tina- (tiuni-) гэх үгийн үндэс, зээлдсэн үг биш харин монгол хэлний хэлбэртэй нэг гаралтай нийт язгуур гэж үзэвл монгол-хамниган нийт өвөг хэлэнд * temgü- ~+ *timgü-г дахин бүтээж болох магадгүй.

Н. Поппе гуай монгол хэлний tegü- гэсэн бүтээврийн тухай ингэж үзэж байна.

mo. tegü < *tebü- 'pflücken, sammeln' = ew. tewlize< *tewilize. id."/Poppe, 1960, p. 133/

Жич: тэвли-ми 1. собирать ягоды /цэцэг түүх/, 2. шелушить кедровые орехи, тэвлэ-ми "собирать ягоды" /Василевич 1958 , 417 тал/

Поппе гуай тэнд temgü- гэдэг бүтээврийг ерөөс дурдахгүй юм. Миний бодоход монгол бичгийн хэлний tegu- нь temgu- гээс хөгжиж хувирсан юм болж temgü-> tengü-> tegü- гэж үзвэл зохино байх. Тэгэхлээр энэ үгтэй холбогдуулан монгол хэлний үйл үгийн үндэс cimki-"чимх-ийг" харьцуулж үзье. Энэ нь түрк хэлнүүдэд ч зохицох хэлбэр нь үзэгдэнэ. Тухайлбал:

mo. cimki- < *cimki- 'kneifen'= oir. cimci- id., kha. cimzila- id.,
bas. semet- id., osm. cimdik 'Aniff (Poppe, 196K, p. 26)

Монгол хэлнүүдийн дотор тэмдэглэгдэх хэлбэр нь монгор хэлний үг ts'inGi –< cimki- "pincer" /чимх-/ болно биз. Үүнийг дээр дурдсан temgu-, тунгу-тэй харьцуулж үзвэл авиалбар болон утга зүйн талаар нэг төрлийн шинжтэй юм. Бас cimki-гийн хөгжлийн түүхийг дурдвал *timki-> cimki-> cimki- гэж тайлбарлаж болно.

Тийм учраас temgu-, cimki- хоёр хэлбэрийг нь угаас эгшиг сэлгэхээр болсон үгийн гарлаар харилцан холбогдолтой хэлбэр гэж үзэх боломжтой юм.

Ашигласан хэвлэл

1. Ц. Дамдинсүрэн, Ш. Гаадамба, Монголын Нууц Товчоо. Улаанбаатар, 1976
2. Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966
3. Н. Поппе. Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, часть 1-2, Москва, 1938
4. К. М. Черемисов. Бурятско-русский словарь. Москва, 1973
5. Б. Х. Тодаева. Монгорский язык. Москва, 1973
6. —"— Баоаньский язык, Москва, 1964
7. В. И. Цинциус. Сравнительный словарь тунгуско-маньчжурских языков. 1,2. Ленинград, 1975, 1977
8. Г. М. Василевич. Эвенкийско-русский словарь. Москва, 1958
9. Т. Дашцэдэн. Монголын нууц товчоо. Улаанбаатар, 1985
10. N. Poppe. Vergleichende Grammatik der Altaischen Sprachen, Teil 1, Vergleichende Lautlehre, Wiesbaden, 1960
11. G. J. Ramstedt. Kalmuckisches Worterbuch, Helsinki, 1935
12. Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972
13. A. De Smedt et A. Mostaert, Le Dialecte Monguor Parle par les Mongols du Kansou Occidental, 3. Pei-p'ing, 1933
14. F. Lessing, Mongolian-English Dictionary, Berkeley and Los Angels, 1960
15. E. Hauer, Handworterbuch der Mandschusprache, 1,2,3. Tokyo-Hamburg, 1952, 1955
16. 「元朝秘史三種」京都 1975
17. 布林特古斯「蒙古正音字詞典」集宁 1977
18. 思和巴圖「达汉小词典」呼和浩特 1983
19. 李树兰，仲謙「锡伯语简志」北京 1986
20. 布和，刘照雄「保安语简志」北京 1982
21. 「土汉对照词汇」云南土族自治县 1982
22. 羽田亨「滿和辭典」東京 1972
23. 山本謙吾「滿洲語口語基礎語彙集」東京 1969

Д. Цэдэв /БНМАУ/

СҮҮЛИЙН ҮЕИЙН МОНГОЛ ЯРУУ НАЙРГИЙН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ДИАЛЕКТИКИЙН АСУУДАЛД

Монгол яруу найргийн нэгэн гол шинж бол уламжлал, шинэчлэлийн уялдаа холбооны асуудалд байдаг. Энэ нь яруу найргийн төрөл зүйл бүр дээр нарийвчлан ярьж болох ергөн цар хүрээтэй ойлголт, нөөөтэйгүүр олон улсын монголч эрдэмтний түрүүчийн хөөр их хурал дээр миний бие 1920-1940-өөд оны монгол яруу найргийн уран дүрслэлийн уламжлалын тухай болон 1940-1950-иад оны туульсын яруу найргийн уламжлал, шинэчлэлийн асуудлыг хөндөж илтгэл тавьсан учраас энэ удаад тэдгээрийн үргэлжлэл болгож сүүлийн үеийн нэн яаралтуяа 1960-1970 -аад оны иргэний уянгын яруу найргийн жишээнд тулгуурлаж зарим санаагаа өгүүлэхийг эрмэлзсэн болно. 1960-1970-аад оны гэж цохон заач үзэхийн учир нь энэ үед монголын шинэ үеийн иргэний уянгын яруу найргийн өрнөл хөгжлийн нэгэн чухал үе богөөд түүний нэрт төлөөлөгчдийн гол гол бүтээл гарсан хэмээн үзэж болно. Энэ үеийн яруу найрагчдын бүтээлийн сэдвийн цар хүрээ нь өргөжиж, агуулгын хувьд гүнзгийрэн уран чадвар нь өссөн юм. Тийм ч учраас дурдсан үеийн монголын яруу найргийн нэгэн гол ажилят нь иргэний уянгын найргийн бодол эргэцүүлэлийн шинж давамгайлах болсон явдал болно. Энэ бол манай яруу найрагчдын уламжлалын баян сангаас хөндийрч тасралтгүйгээр зөрөлтгүй эрэл хайгуул хийсний үр дүн мөн.

Монгол ардын аман зохиолын болон бичгийн утга зохиолын дэвшилт уламжлал нь манай шинэ үеийн утга зохиолын хөгжих үндэс болж, манай зохиолчдын амьдралыг реалист ёсоор дүрслэх арга ухааныг эзэмшихэд суурь дэлгэр болсоор ирсэн билээ. Иймээс уламжлал гэдэг нь бодит байдлыг танин мэдэхүйн олон үеийн хуримталсан туршлагын үр дүн, өмнөх үеийнхний бий болгосон дүрийн сэтгэлгээний хөгжлийн төвшин гэдэг нь эргэлзээгүй юм. Иймхүү уламжлал нь 1960-1970-аад оны иргэний уянгын яруу найрагт өмнөх үеийнхийг бодвол нэлээд өвөрмөцөөр илэрсэн гэж болно. Үүнд:

1. 1920-40 оны үеийн яруу найрагт аман зохиолын бөлэн хэв загварыг ашиглах, ерөөл магтаалын аясаар бодит байдлыг дүрслэх хандлага нэлээд байсан бол дурдсан сүүлийн үеийн яруу найрагт аман зохиолын зарим зохиомж, дүр сэлтийг ариглахдаа бодит байдал дээр нягт уригуулан дүрслэх болсон байна. Ардын аман зохиолын уламжлалт арга болох адилтгал, зүйрлэл, хэтрүүлэг, чимэг үг тэргүүтнийг зохист газар нь оновчтой хэрэглэсний жишээнд Б.